



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2020 оны 08 сарын 28 өдөр

Дугаар А/153

Улаанбаатар хот

Түр заавар шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, Захиргааны ерөнхий хуулийн 4.2.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Коронавируст халдвар (COVID-19)-ын батлагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэлийн Онцгой комисс, Эрүүл мэндийн газар, өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3. Уг тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төв (Г.Уянга), Халдварт өвчин судлалын үндэсний төв (Д.Нямхүү), Зоонозын өвчин судлалын үндэсний төв (Д.Цогтбадрах)-д тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/153 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Т.МӨНХСАЙХАН

141201542

Эрүүл мэндийн сайдын 2020 оны 08.
дугаар сарын 18-ны өдрийн 4/ дугаар
тушаалын хавсралт 4/к



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (COVID-19)-ЫН БАТЛАГДСАН БОЛОН СЭЖИГТЭЙ ЦОГЦСЫГ ОРШУУЛАХАД БАРИМТЛАХ ТҮР ЗААВАР

1. Коронавируст халдвар (COVID-19)-тай нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан, эмнэлзүй, тархвар судлалаар сэжигтэй тохиолдол гэж үзсэн тохиолдолд задлан шинжилгээ хийхгүй.

2. Улсын болон нийслэл, тухайн орон нутгийн онцгой комисс нь коронавируст халдвар (COVID-19)-аар нас барсан хүний цогцсыг зөөвөрлөх тээврийн хэрэгсэл, хадгалах байр, оршуулах газрыг урьдчилан судалж, шийдвэрлэсэн байна.

3. Коронавируст халдварын сэжигтэй болон онош батлагдсан өвчтөн нас барсан даруйд тухайн эрүүл мэндийн байгууллага нь оршуулах бэлтгэлийг хангах зорилгоор харьяа нийслэл, орон нутгийн онцгой комисст мэдээлнэ.

4. Коронавируст халдвар батлагдсан болон сэжигтэй тохиолдол эмнэлгийн бус нөхцөлд нас барсан үед хууль сахиулах байгууллага халдвараас сэргийлэх дэглэм баримтлан цогцсыг зөөвөрлөн, 2-т заасан хадгалах байранд хүргэнэ.

5. Коронавируст халдвар батлагдсан болон сэжигтэй цогцсыг улс, бүс нутаг, орон нутаг хооронд шилжүүлэхийг хатуу хориглоно.

6. Цогцостой харьцах хүмүүс хамгаалах хувцас, хэрэгслийг өмсөх, тайлах, халдвартай цогцостой харьцах, гар халдваргүйжүүлэх талаар сургалтад хамрагдсан байна.

7. Цогцсыг зөөвөрлөх, хадгалах, бэлтгэх үйл ажиллагаа

7.1. Цогцсыг шингэн нэвчихгүй зориулалтын уутанд хийж, уутны бүх гадаргууг халдваргүйжүүлэн, "халдварын эрсдэлтэй" гэж тэмдэглэн зөөвөрлөнө.

7.2. Биологийн шингэн нэвчих эрсдэлтэй үед цогцсыг 2 давхар уутанд хийнэ.

7.3. Цогцос байршуулсан, тавьсан гадаргууг цэвэрлэгээний бодистой уусмалаар угаасны дараа нь халдваргүйжүүлж, цэвэрлэнэ.

7.4. Нас барсан хүний хувцас, бусад зөөлөн эдлэлийг шар өнгийн уутанд хийж, аюултай хог хаягдлыг устгах журмын дагуу устгана.

8. Оршуулах үйл ажиллагаа

8.1. Онцгой комисс нь мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн оршуулах шийдвэрийг гарган, хууль сахиулах, эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл оролцуулан хяналт тавих багийг томилно.

8.2. Цогцсыг зориулалтын газарт чандарлах болон булшлах аргаар оршуулах бөгөөд ил тавихыг хориглоно.

8.3. Булшлах аргаар оршуулах тохиолдолд хяналтын багийн удирдлага дор ар гэр гүйцэтгэнэ.

- 8.4. Оршуулгын үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа ар гэр болон ажилтнууд эмнэлгийн зориулалтын амны хаалт болон бээлий өмсөнө.
- 8.5. Цогцыг оршуулах, зан үйлтэй холбоотой аливаа үйлдлийг хязгаарлаж, цогцостой харьцах хүний тоог цөөн байлгана.
- 8.6. Оршуулах үйл ажиллагаанд оролцож байгаа гэр бүлийн гишүүдийг цогцост хүрэхийг хориглоно.
- 8.7. Оршуулгын үйл ажиллагаанд оролцсон бүх хүмүүс гараа угааж, халдваргүйжүүлнэ.
- 8.8. Хяналтын баг оршуулгын үйл ажиллагааны тэмдэглэл хөтөлж багийн гишүүд бүгд гарын үсэг зурж баталгаажуулна.

9. Шалтгаан тодорхойгүй уушгины цочмог үрэвсэл өвчнөөр нас барсан, коронавируст халдвар (COVID-19)-ын эмнэлзүй болон тархвар зүйн холбогдолгүй цогцост задлан шинжилгээ хийх эмнэлгийн мэргэжилтэн, туслах ажилтан, хууль сахиулах байгууллагын албан хаагчид нүдний шил, нүүрний хаалт, гутал, урт ханцуйтай, шингэн нэвтэрдэггүй халад, комбинзон, усны хамгаалалттай хормогч, агаарын дуслыг 95% буюу түүнээс дээш шүүх үзүүлэлттэй шүүлтүүр бүхий амны хаалт, ахуйн бээлий өмсөнө.